


Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газрын  
даргын 2021 оны 02 дугаар сарын 05-ны  
өдрийн .../10 дугаар тушаалын хавсралт



## **ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ЕРӨНХИЙ ШААРДЛАГА**



**Цахилгаан, сантехник, мужааны ажил гүйцэтгэхэд инженер,  
техникийн ажилтны аюулгүй байдлыг хангах ерөнхий  
шаардлага**

# **ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ЕРӨНХИЙ ШААРДЛАГА**

Цахилгаан, сантехник, мужааны ажил гүйцэтгэхэд инженер,  
техникийн ажилтны аюулгүй байдлыг хангах  
ерөнхий шаардлага

## БАЙГУУЛЛАГЫН СТАНДАРТ

| Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ерөнхий шаардлага  |
|--|
| 1. Инженер, техникийн ажилтны хөдөлмөрийн аюулгүй байдал<br>2. Дулаан, сантехникийн ажилтны хөдөлмөрийн аюулгүй байдал<br>3. Цахилгаан хангамжийн хөдөлмөрийн аюулгүй байдал<br>4. Цахилгаан хүчдэлтэй газар ажиллах зааварчилгаа<br>5. Мужааны хөдөлмөрийн аюулгүй байдал |

Энэ стандартын шаардлагыг заавал мөрдөнө.

### 1. Хамрах хүрээ

Энэхүү стандарт нь Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газрын ажилтан, албан хаагчдад хамаарна.

### 2. Зорилго

Ажилтан, албан хаагчид ажил үүргээ гүйцэтгэх үедээ зайлшгүй баримтлах хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хэм хэмжээг тогтооход оршино.

**3. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй** гэж хөдөлмөрлөх явцад хүний ажиллах чадвар, эрүүл мэндийг хэвээр хадгалах, эрүүл аюулгүй нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн нийгэм, эдийн засаг, зохион байгуулалт, техник, технологи, ариун цэвэр, эрүүл ахуйг арга хэмжээ авах, эмчлэх, сувилах, нөхөн сэргээх, эрсдэлээс хамгаалах үйл ажиллагааг хэлнэ.

### 4. ИНЖЕНЕР, ТЕХНИКИЙН АЖИЛТНЫ ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ

4.1 Халаалтын системийн узельд шууд өгөх буцах даралтын шугам, түүний халаалтуудад байнга үзлэг үйлчилгээ хийх, үйлчилгээ хийхдээ системийн даралттай усыг огцом тавих, хаах явдлаас болгоомжилж аюулгүй байдлыг бүрэн хангасан байна.

#### Хүснэгт №1. Шалгуур үзүүлэлтүүд

| № | Үндсэн шаардлага                                      | Тийм | Үгүй |
|---|---|------|------|
| 1 | Температурын заалт хэвийн ажиллаж байгаа эсэх         | ○    | ○    |
| 2 | Халаалтын системийн өгөх буцах даралтыг шалгасан эсэх | ○    | ○    |
| 3 | Халаалтын шугамыг өнгөөр ялгаж будсан эхэс            | ○    | ○    |
| 4 | Халаалтын системийн хаалт бүрэн ажиллаж байгаа эсэх   | ○    | ○    |

ТАЙЛБАР: Дээрх үндсэн шалгах үзүүлэлтүүд бүгд тийм гэж тэмдэглэгдсэн байх шаардлагатай.

4.2 Ажлын байранд ажилтнууд ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгсэл байнга хэрэглэж байх. Үүнд

- 4.2.1 бээлий;
- 4.2.2 ажлын тусгай хувцас;
- 4.2.3 чийгнээс хамгаалсан гутал;
- 4.2.4 амны хаалт.

ТАЙЛБАР: Инженер техникийн ажилчдын ажлын хувцас, багаж хэрэгсэл нь чанарын шаардлагыг бүрэн хангасан, ус чийг, халуун ус, уур, цахилгаан хүчдэлээс хамгаалсан байх шаардлагатай.

4.3 Засвар үйлчилгээг тохирсон багаж ашиглан хийх ба багажны бүрэн бүтэн байдлыг шалган ажилд гарна.

4.4 Хүнд, овор ихтэй тоноглолуудыг солих, засварлахдаа мэргэжлийн удирдлагын зааварчилгааг авч, технологийн горимын дагуу ажиллаж акт үйлдэнэ.

4.5 Өндөр болон температурын эрс тэс /хэвийн бус/ нөхцөлд мэргэжлийн удирдлагын хяналтгүйгээр үйлчилгээ хийхийг хориглоно.

*Хүснэгт №2. Шалгуур үзүүлэлтүүд*

| № | Үндсэн шаардлага   | Тийм | Үгүй |
|---|--|------|------|
| 1 | Тохирсон багаж хэрэгсэл ашиглаж байгаа эсэх                  | ○    | ○    |
| 2 | Инженерийн заавар зөвлөмжийн дагуу гүйцэтгэж байгаа эсэх     | ○    | ○    |
| 3 | Тухайн ажлыг технологийн горимын дагуу гүйцэтгэж байгаа эсэх | ○    | ○    |

ТАЙЛБАР: Дээрх үндсэн шалгах үзүүлэлтүүд бүгд тийм гэж тэмдэглэгдсэн байх шаардлагатай.

**5. ДУЛААН, САНТЕХНИКИЙН АЖИЛТНЫ ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ**

5.1 Сантехникийн систем, түүний тоноглолын ажиллах горим, технологийн онцлогийг сайтар судалж, түүнд үзүүлэх техникийн үйлчилгээг зохих журмыг баримтлан ажиллах;

5.2 Өөрийн болон бусдын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар мөрдвөл зохих норм, дүрэм, журмуудыг чандлан биелүүлэх;

5.3 Ажлын байранд согтууруулах ундаа хэрэглэх, ажлын байрыг эзэнгүй орхиж явах, гаднын хүмүүсийг ажлын байранд цуглуулах, удирдлагын зөвшөөрөлгүйгээр өөр хүнд ажил хариуцуулан орхих зэрэг алдаа гаргахгүй байх;

5.4 Бохирын шугам, газар доорх системд агааргүй орчин бүрдсэн байж болзошгүйг анхаарахын зэрэгцээ хуралдсан хорт хий бусад нөлөөллөөс эрүүл ахуй талаас хамгаалалт сайн хийж ажиллах, хорт хийг гадагшилж агаар сэлгэсний дараа ажил үйлчилгээг хийх;

*Хүснэгт №3. Шалгуур үзүүлэлтүүд*

| № | Үндсэн шаардлага   | Тийм | Үгүй |
|---|--|------|------|
| 1 | Сантехникийн систем, техникийн үйлчилгээг гүйцэтгэхдээ сайтар судалсан эсэх  | ○    | ○    |
| 2 | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм, журмыг биелүүлсэн эсэх        | ○    | ○    |
| 3 | Ажлын байранд архи согтууруулах ундаа хэрэглэсэн эсэх                        | ○    | ○    |
| 4 | Бохирын шугамын ажил гүйцэтгэхдээ эрүүл ахуйн хамгаалалтаа бүрэн хийсэн эсэх | ○    | ○    |
| 5 | Хорт хийг гадагшилж агаар сэлгэсний дараа ажил үйлчилгээг хийсэн эсэх        | ○    | ○    |

ТАЙЛБАР: Дээрх үндсэн шалгах үзүүлэлтүүд бүгд тийм гэж тэмдэглэгдсэн байх шаардлагатай.

5.5 Халаалтын систем болон халуун хүйтэн усны системд үйлчилгээ хийхдээ төвийн гол шугамуудын хаалтуудыг бүрэн хааж ажиллах.



*Зураг. №1. Халаалтын систем болон халуун хүйтэн усны хаалтуудын харагдах байдал*

## **6. ЦАХИЛГААН ХАНГАМЖИЙН ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ**

6.1 Цахилгаан тоног төхөөрөмж, техник хэрэгслийг хүчдэлээс салгасны дараа засвар үйлчилгээ хийх;

6.2 Агуулах, номын сан, архивын өрөө зэрэг бичиг цаасны дэргэд цахилгаан техник, тоног төхөөрөмж ил тавьж ашиглах, засварлахгүй байх, цахилгаан шугамыг хамгаалах хэрэгсэлгүй угсрахгүй байх;



*Зураг. №2. Цахилгааныг хүчдэлээс салгасны дараах харагдах байдал*


6.3 Ажиллаж байгаа цахилгаан техник хэрэгслийг эзэнгүй орхих, эвдрэл гэмтэлтэй цахилгаан хэрэгслийг ажиллуулахгүй байх;

6.4 Розетка, унтраалгыг бэхэлгээгүй, хөдөлгөөнтэй угсарч болохгүй;

Зураг. №3.



**ЗӨВ**



**БУРУУ**

6.5 Цахилгаан тоног төхөөрөмж дээр цавуу, цаас, будаг зэрэг хялбар шатах материал тавихгүй байх;

Зураг. №4.



**ЗӨВ**



**БУРУУ**

6.6 Цахилгаан дамжуулах утсыг тогтоох, сул татаж өлгөх, гар хийцийн гал хамгаалагч, зориулалтын бүрхүүлгүй уртасгагч, гэрлийг галын аюултай газруудад тавьж ашиглахгүй байх;



Зураг.№5. Цахилгааны щитны өрөөнд эд материал хурааж хадгалж болохгүй.

6.7 Цахилгааны щит техникийн өрөөг ажил үйлчилгээний зориулалтаар ашиглаж, эд материал хадгалахгүй байх;

6.8 Ажлын хамгаалах бээлий, хамгаалалттай багаж хэрэглэх;



*Зураг.№ 6. Ажлын шаардлага хангасан багаж, өндрийн зориулалт бүхий бээлий*

6.9 Гар удирдлагатай тоолуур, салгуур, тусгаарлагчийг тасалсны дараа ажиллах, тэдгээрийн фаз нь таслагдсан байдал, далд түр холбоос үүсээгүйг биечлэн шалгасан байх;

6.10 Засвар үйлчилгээ хийж байгаагаас бусад тохиолдолд цахилгаан байгуулалтын байр, щит, цуглуулга, шүүгээний хаалга цоожтой байна.

6.11 **Цахилгаан хүчдэлтэй газар ажиллахдаа:**

6.11.1 тусгаарлагч резин шаахайтай, эсвэл тусгаарлах тавиур буюу резин дээр зогсож ажиллах;



*Зураг.№ 7. Тусгаарлагч резин гутал, резин шал шалны харагдах байдал*

6.11.2 төмрийн хөрөө, хуурай, төмөр метр ашиглахгүй байх;

6.12 Харанхуй үед ажлын байр, түүнд хүрэх зам, орц гэрэлтүүлэгтэй байх ёстой.

Хүснэгт №4. Шалгуур үзүүлэлтүүд

| № | Үндсэн шаардлага  | Тийм                  | Үгүй                  |
|---|---|-----------------------|-----------------------|
| 1 | Цахилгаан тоног төхөөрөмж, техник хэрэгслийг хүчдэлээс салгасан эсэх            | <input type="radio"/> | <input type="radio"/> |
| 2 | Цахилгаан шугамыг хамгаалах хэрэгсэлгүй угсрасан эсэх                           | <input type="radio"/> | <input type="radio"/> |
| 3 | Ажиллаж байгаа болон эвдрэл гэмтэлтэй цахилгаан хэрэгслийг эзэнгүй орхисон эсэх | <input type="radio"/> | <input type="radio"/> |
| 4 | Розетка, унтраалгыг хөдөлгөөнтэй угсарсан эсэх                                  | <input type="radio"/> | <input type="radio"/> |
| 5 | Ажлын хамгаалах бээлий, хамгаалалттай багаж байгаа эсэх                         | <input type="radio"/> | <input type="radio"/> |

ТАЙЛБАР: Дээрх үндсэн шалгах үзүүлэлтүүд бүгд тийм гэж тэмдэглэгдсэн байх шаардлагатай.

**7. МУЖААНЫ ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ**

7.1 Хөдөлмөрийн тохирсон багаж ашиглах.

Үүнд:

7.1.1 ир сайтай багаж ашиглах;

7.1.2 отвертка, бахь, хөрөө, сүх, харуул, цүүц /цахилгаан ба гар ажиллагаатай/ ирний хамгаалалттай байх;



Зураг.№8. Ир сайтай, ирний хамгаалалт бүхий ажлын багаж

7.1.3 шаардлагатай тохиолдолд хамгаалах малгай, ажлын бээлий өмсөх, нүдний хамгаалалтын шил зүүх;



Зураг.№9. Хамгаалалт бүхий малгай, нүдний шил



- 7.2 Цахилгаан ба гар багажтай зөв харьцаж, эзэмших аюулгүй ажиллагааг хангах;  
7.2.1 багажид гар хуруу, бие эрхтнээ гэмтээхээс болгоомжлон ажиллах;
- 7.3 Шат, вандан, цонхноос унаж гэмтэхээс сэрэмжлэх;
- 7.4 Нүдрүү модны үрдэс зомгол үсэрч орохоос хамгаалах.

*Хүснэгт №5. Шалгуур үзүүлэлтүүд*

| № | Үндсэн шаардлага   | Тийм | Үгүй |
|---|--|------|------|
| 1 | Чанарын шаардлага хангасан, хөдөлмөрийн нөхцөлд тохирсон багажтай эсэх | ○    | ○    |
| 2 | Цахилгаан ба гар багажны ажиллагаа хэвийн, ир хэвийн эсэх              | ○    | ○    |
| 3 | Хамгаалалтын малгай, нүдний шил байгаа эсэх                            | ○    | ○    |
| 4 | Өндөрт ажиллах тохиолдолд хамгаалалтын бэхэлгээг бүрэн хийсэн эсэх     | ○    | ○    |
| 5 | Хөдөлмөр хамгааллын зааварчилгаа авсан эсэх                            | ○    | ○    |

ТАЙЛБАР: Дээрх үндсэн шалгах үзүүлэлтүүд бүгд тийм гэж тэмдэглэгдсэн байх шаардлагатай.

### 8. АЖЛЫН ТУСГАЙ ХУВЦАС

8.1 Хөдөлмөрийн тохирсон хувцас хэрэглэх. Ажлын хувцас нь “Ажлын тусгай хувцас”-ны ерөнхий шаардлага MNS13688:2000 Монгол улсын стандартыг хангасан байна.

Үүнд:

- 8.1.1 Ажлын тусгай хувцасны материал, бүрдэл хэсгүүд нь хүнд саад болохгүй;
  - 8.1.2 Хүнийг шаардагдах түвшинд хамгаалахаас гадна биед дээд зэргээр тохиромжтой байх;
  - 8.1.3 Хүний биед хүрэлцэх хувцасны хэсгүүд нь аливаа цочроо, шархлаа үүсгэхгүй, ширүүн, хурц ирмэггүй байх;
  - 8.1.4 Хувцасны дизайн нь хөдөлмөрийн нөхцөл, биеийн хөдөлгөөний онцлогт тохирсон байхаас гадна хувь хүнд тохируулан хэмжээг нь өөрчилж болохуйц буюу хэмжээний өргөн сонголттой байх;
  - 8.1.5 Хөдөлгөөн болон гадаад орчны хүчин зүйлүүдийг тооцсон хэрэглээний хугацааг урьдаас тооцож баталгаажуулсан байх;
  - 8.1.6 Хувцасны хамгаалалтын түвшингийн найдваржилт өндөр, бөх бат хийгдсэн, хөнгөн, эдийн засгийн хувьд үр ашигтай байх;
- Ажлын тусгай хувцас нь боломжийн хирээр ус ба уур нэвтрүүлэхгүй байна.

